



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 200

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн факторингийн
үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хай бриж кредит ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Хай бриж кредит ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэл хийлгэхийг “Хай бриж кредит ББСБ” ХХК /Б.Баянмөнх/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН